



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.01 № 03/10174

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг 2014 оны 09 дүгээр сарын 10-наас 2014 оны 09 дугаар сарын 17-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцлаа.

Үйл ажиллагаандаа Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг удирдлага болгон дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга Т.Нямцэцэг нартай уулзаж ярилцан нөхцөл байдлыг танилцуулж ажилласан байна.

Тус дүүргийн Тамгын газар, харьяа хэлтэс агентлагуудын төлөөлөлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах мэдээлэл бүхий 15 асуулттай мэдлэг сорих тест боловруулан ажлуулж, оролцооны аргыг ашиглан үр дүнд чиглэсэн мэдээлэл өгөх хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 56, “Авлига, ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал” сэдвээр зохион байгуулан сургалтад 664 төрийн албан хаагч оролцлоо.

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбараар болон байгууллагын цахим хуудсаар төсөв санхүүтэй холбогдох мэдээллийг ил тод болгоход чиглэсэн томоохон алхмыг хийсэн байна. Тухайлбал, Шилэн данс нэртэй мэдээллийн самбар ажиллуулж, байгууллагын цахим хуудсаар тухайн онуудын төсөв түүнтэй холбогдох мэдээллийг нээлттэй байршуулан тухай бүр шинэчилдэг нь сайшаалтай байна.

Харин иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, хэрэгцээ хангахуйц мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх, тухайлбал, худалдан авах ажиллагаа, хүний нөөцтэй холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих түвшинд байгууллагын цахим хуудсаар мэдээлэх санаачилга дутмаг байна.

Дүүргийн босоо удирдлагатай төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал харьцангуй зохих түвшинд байна.

021466

Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан авлигын эсрэг үйл ажиллагаатай холбогдох бүртгэл хөтлөлтүүдийг зөвхөн хөрөнгө, орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, түүнтэй холбоотой мэдээ тайлан гаргах төдийгээр хязгаарлаж, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмаар /Эрх бүхий албан тушаалтан/-д хүлээлгэсэн нийтлэг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн албыг цэвэр, шударга, тэгш зарчмаар явуулах удирдлагын хүчин чармайлт нэн дутмаг, хууль ёсыг дээдлэн сахих ёс зүй бүрэн төлөвшөөгүй, улс төржсөн хандлага ихтэй гэж дүгнэж үзэхээр байгаа тул дүүргийн удирдах албан тушаалтнуудад тусгайлсан авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Дүүргийн удирдлагаас авлигын эсрэг хууль тогтоомжоор авлигаас ангид байхад чиглэсэн төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэсэн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх талаарх санаачилга сул байгаагаас Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрүүд ихээр гаргасан байна.

Ялангуяа албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд болон үүсэхээс сэргийлсэн мэдэгдэл, тайлбараа зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх үүргийг хэрэгжүүлж хэвшээгүйн улмаас албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, давуу байдал олгох, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах, хандив бэлэг авах, өгөх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлүүдийн шинжийг агуулсан шийдвэрүүд гаргасны заримаас дурдвал;

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн Б/07 дугаатай “Дүүргийн 50 жилийн ойг зохион байгуулах дэд ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гарган захирамжийн 4 дүгээр хавсралтаар “гадаад, дотоодын төлөөлөгчид, хандив, тусламж хариуцсан дэд ажлын хэсгийг Тамгын газрын дарга Т.Нямцэцэгээр ахлуулсан байх бөгөөд 10 удаагийн шилжүүлгээр нийт 74.0 сая төгрөгийн хандив 2014 оны 9 дүгээр сарын 11-ны өдрийн байдлаар төвлөрүүлсэн байна. Энэхүү хандив авсан асуудал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийг;

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг “... ардын хувьсгалын ой болон нийслэлийн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.” гэж заасан байтал дүүргийн Засаг даргын 2013 оны А/399, А/401, А/411, А/436 дугаартай захирамжуудаар 15.559.835 төгрөгийг, 2014 оны А/627, А/630, А/634, А/710 дугаартай захирамжууд, Засаг даргын Тамгын газрын даргын А/157 дугаар тушаалаар тус тус нийт 35.410.810 төгрөгийг дүүргийн хэмжээнд улсын баяр наадам тэмдэглэхэд зарцуулсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг;

Баянгол дүүргийн Засаг даргын 2013 оны 7-р сарын 19-ны өдрийн А/439 дугаартай захирамжаар Архангай аймагтай хамтын ажиллагааны хүрээнд Хайрхан суманд зохион байгуулагдах арга хэмжээ, сургалтад тус дүүргийн 70 ажилтан оролцох зардалд 28.0 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “ ... төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” тухай заалт болон Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг;

Баянгол дүүргийн Засаг даргын 2014 оны 3-р сарын 14-ны өдрийн А/192 дугаартай захирамжаар “Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үед шаардлагатай Онцгой комиссын гишүүдэд олгох хувцасны зардалд 4 200 000 төгрөгийг зарцуулсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

2013 оны дүүргийн Засаг даргын А/684 дүгээр захирамжаар БНХАУ-ын Хайнан мужид туршлага судлах /аялах/ арга хэмжээнд 17.4 сая төгрөгийг гадаад арга хэмжээний зардлаас гаргажээ. Уг асуудлыг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагч шалгаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг зөрчсөн байна гэж үзэн 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 02.08.33/211 дугаартай албан томилолтын зардал болох 8.893.145 төгрөгийг нөхөн төлүүлэх акт тавьсан байна.

Ийнхүү Хэвлэл мэдээлэлийн байгууллагатай хамтран ажиллах /... гүйцэтгэгч тал нь захиалагч талтай холбоотой болон нэр хүндэд нь халдсан сөрөг мэдээ мэдээлэл, нийтлэл, ярилцлага зэргийг нийтлэхгүй гэсэн байхаар заасан/ гэрээг байгуулсан байна. Уг гэрээний дагуу Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2013 онд Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллахад 64.5 сая төгрөг, 2014 онд 53 100 000 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Хэвлэл мэдээлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтуудыг зөрчсөн гэж үзэхээр байна.

Баянгол дүүрэг улсын болон орон нутгийн төсөв, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 2013 онд 142, 2014 онд 158 удаа зохион байгуулжээ.

Үүнээс Засаг даргын захирамжаар 2013 онд Үнэлгээний хороо байгуулсан 50 удаагийн шийдвэрийн 34-т, 2014 онд Үнэлгээний хороо байгуулсан 82 удаагийн шийдвэрийн 74-т нь нэг албан тушаалтан /Засаг даргын орлогч Г.Энхболд/-ыг Үнэлгээний хорооны даргаар томилон ажиллуулсан нь авлигын эрсдэл үүсэх нөхцөл боломжийг өндөр болгож байгааг урьдчилан сэргийлж, зохих арга хэмжээг аваагүй байна. Тухайлбал, байгууллагаас авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаалын жагсаалтыг баталсан байх, түүний дагуу сэлгэн ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх

мэдэгдэл тайлбарыг байнга гаргуулах, дотоод хяналт шалгалт явуулах, үр дүнг хэлэлцэх гэх мэт.

Баянгол дүүргийн Засаг даргын орлогч Г.Энхболд нь Засаг даргын 2013 оны А/357 дугаар захирамжаар байгуулагдсан “Хогийн цэг байгуулах” ажил үйлчилгээний сонгон шалгаруулалтыг явуулах Үнэлгээний хорооны даргаар ажиллахдаа өөрийн эхнэр Э.Содгэрэлийн төрсөн эцэг С.Эрдэнийн үүсгэн байгуулсан “Молор Констракшин” ХХК-г шалгаруулсах шийдвэрийг гаргахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах үүргээ хэрэгжүүлээгүй, тайлбараа гаргаж татгалзаагүй, энэ талаарх мэдээллээ “Мэдэгдэл тайлбар, мэдээлэл тэдгээрийн шийдвэрлэлтийн цахим бүртгэл”-д оруулж бүртгүүлээгүй байна.

Мөн Тамгын газрын байрны орох хэсгийн тохижилтын ажлын худалдан авах ажиллагааг хянан үзэхэд; уг ажлыг Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдын хурлын 2014 оны 19/02 дугаартай тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгийн давсан орлогоор санхүүжүүлэхээр шийдвэр гарч дүүргийн Засаг даргын 2014 оны А/332, А/333 дугаар захирамжаар ажлын хэсгийг Засаг даргын орлогч Г.Энхболдоор ахлуулан байгуулж тендерийн урилгыг “Санбилэг” ХХК, “Халзан бүргэдэй” ХХК, “Агарын гол” ХХК-иудад хүргүүлэн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдөр тендер нээж, тухайн өдрөө “Санбилэг” ХХК-ийг шалгаруулсан тухай зөвлөмжийг гаргасан байна.

Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар зарлагдаж байгаа ажлуудын тендерийн урилгыг тус албанд бүртгэлтэй байгаа 3 аж ахуйн нэгжид хүргүүлэн дүүргийн [www.bgd.mn](http://www.bgd.mn) урилгыг тавьдаг гэсэн тайлбарыг Худалдан авах ажиллагааны албаны ажилтан өгсөн бөгөөд тайлбарын дагуу нягталж үзэхэд “Санбилэг” ХХК-ний хүсэлт тус албанд байсан бөгөөд нөгөө хоёр компаний хүсэлт байхгүй, урилгыг [www.bgd.mn](http://www.bgd.mn) сайт болон Худалдан авах ажиллагааны [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) сайтад байршуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дугаартай тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх” журмаар хэрэглэх эрх олгоогдоогүй байхад 2013 онд Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 3 удаагийн тушаалаар 2 072 000 төгрөгөөр тусгай гэрлэн болон дуут дохио худалдан авч ашиглаж байгаа нь тул Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.7 дэх заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурьдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулан, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтын дагуу Зөвлөмж болгож байна.

Зөвлөмжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2014 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ